

$$)= \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u} du \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda)) \quad \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u} du \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda)) \quad \text{Re} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u} du \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda))$$

$$f(t+\tau) d\tau, f(t+\tau), u = \frac{1-K^2 r^2}{(1+K^2 r^2)^2}, v = \frac{2Kr}{1+K^2 r^2}$$

$$E(\tau) = \int_{-\infty}^{\infty} \int_{-\infty}^{\infty} a \cdot (t+\tau) f(t, \tau) b \cdot \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u} du \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda))$$

$$= \frac{-2Kr}{(1+K^2 r^2)^2}, u^2 v^2 \sum_{k=1}^{\infty} \frac{1}{k^2} |f(t, \tau)|^2$$

$$Y = \frac{-v}{(u^2+v^2)2K}, u = (u^2+v^2) \left(1 - \frac{K^2 v^2}{4K^2(u^2+v^2)^2}\right), u = \frac{1-K^2 r^2}{(1+K^2 r^2)}, v = \frac{2}{u}$$

$$-(u+v) \frac{v^2}{\phi(u^2+v^2)}, u = f(\tau) \left(1 - \frac{v^2}{4K^2(u^2+v^2)}\right)$$

$$= p^2 - \frac{b}{4} + \frac{\cos^2 \varphi}{4} p = [F(\omega) + iG(\omega)] f(t, \tau) = \int_{-\infty}^{\infty} \kappa$$

$$Y = \frac{-v}{(u^2+v^2)2K}, u = (u^2+v^2) \left(1 - \frac{K^2 v^2}{4K^2(u^2+v^2)^2}\right), u = \frac{1-K^2 r^2}{(1+K^2 r^2)}, v = \frac{2}{u}$$

$$= \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u} du \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda)) \kappa(\omega)$$

$$f(t+\tau) + f(t-\tau) d\tau, P \cos \varphi = p^2 - \frac{\sin^2 \varphi}{4} = p^2 - \frac{b}{4}$$

$$= \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u} du \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda)) \kappa(\omega) = \text{EXP}(i\lambda \tau) P \cos \varphi$$

$$= p^2 - \sin^2 \frac{\varphi}{2}, p^2 = \cos^2 \frac{\varphi}{2}, a(t) = \frac{t}{K} e^{-t}$$

$$f(x) \cdot \kappa \cdot |E[S_{x_1, x_2}^{T_1, T_2}]| + (x_1 - x_2) = \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} \frac{F(u)}{M-u}$$

$$P \cos \varphi = p^2 - \frac{\sin^2 \varphi}{4} = p^2 - \frac{b}{4} + \frac{\cos^2 \varphi}{4} \frac{1}{\pi} \int_{-\infty}^{\infty} e^{i\lambda u} d(M(\lambda))$$

$$p \cos \frac{\varphi}{3} + i p^3 \sin \frac{\varphi}{3} = \frac{1}{1+K}, Y = \frac{-v}{(u^2+v^2)}$$

ART IN EMBASSIES EXHIBITION
United States Embassy Ulaanbaatar, Mongolia

$$P \cos \varphi = p^2 - \frac{\sin^2 \varphi}{4} = p^2 - \frac{b}{4} + \frac{\cos^2 \varphi}{4}, p^2 = 5$$

Nam June Paik **Diatonic**, 1988
Acrylic paint on canvas with additions of television antenna, 30 × 60 in.
Courtesy of the Nam June Paik Estate

Нам Жүн Пайк **Долоон эгшиг** 1988
Зотон, акриль, зурагтын антен, 76,2 × 152,4 см
Нам Жүн Пайкийн гэр-музейн зөвшөөрөлтэй

Art in Embassies

Established in 1963, the U.S. Department of State's office of Art in Embassies (AIE) plays a vital role in our nation's public diplomacy through a culturally expansive mission, creating temporary and permanent exhibitions, artist programming, and publications. The Museum of Modern Art first envisioned this global visual arts program a decade earlier. In the early 1960s, President John F. Kennedy formalized it, naming the program's first director. Now with over 200 venues, AIE curates temporary and permanent exhibitions for the representational spaces of all U.S. chanceries, consulates, and embassy residences worldwide, selecting and commissioning contemporary art from the U.S. and the host countries. These

exhibitions provide international audiences with a sense of the quality, scope, and diversity of both countries' art and culture, establishing AIE's presence in more countries than any other U.S. foundation or arts organization.

AIE's exhibitions allow foreign citizens, many of whom might never travel to the United States, to personally experience the depth and breadth of our artistic heritage and values, making what has been called a "footprint that can be left where people have no opportunity to see American art."

<https://art.state.gov>

Элчин сайдын яамд дахь уран зураг

АНУ-ын Төрийн Департаментын "Элчин сайдын яамд дахь уран зураг" хөтөлбөрийг хариуцсан албыг 1963 онд үүсгэн байгуулсан бөгөөд уг алба нь түр хугацааны болон байнгын үзэсгэлэн, уран бүтээлчдийг оролцуулсан төсөл хөтөлбөрүүд, хэвлэмэл материал зэрэг соёл урлагийн өргөн хэмжээний үйл ажиллагаагаар дамжуулан АНУ-ын олон нийтэд чиглэсэн дипломат үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Үүнээс арван жилийн өмнө Модерн урлагийн музей энэхүү дэлхийн хэмжээний дүрслэх урлагийн хөтөлбөрийг төсөөлөн харж байжээ. Ерөнхийлөгч Жон Ф. Кеннеди 1960-аад оны эхээр хөтөлбөрийг албан ёсоор эхлүүлж, анхны захирлыг нь томилж байв. Одоогийн байдлаар тус хөтөлбөр нь дэлхий даяар 200 гаруй оронд суугаа элчин сайдын яамд, консулын газар, элчин сайдын өргөөний олон нийтэд нээлттэй хэсгүүдэд

АНУ-ын болон оршин суугаа улс орныхоо орчин үеийн урлагийн бүтээлүүдээс сонгон түр хугацааны болон байнгын үзэсгэлэнг зохион байгуулдаг байна. Эдгээр үзэсгэлэнгүүд нь хоёр улсын урлаг соёлын онцлог чанар, цар хүрээ, олон талт байдлыг үзэгчдэд хүргэн АНУ-ын бусад ямар ч сан, урлагийн байгууллагаас илүү олон улс оронд хүрч ажиллаж байна.

Хөтөлбөрөөс гаргадаг үзэсгэлэнгүүд нь АНУ-д зочилж үзээгүй гадаадын иргэдэд Америкийн урлаг соёлын өв, үнэт зүйлсийг бодитоор үзэж мэдрэх боломжийг олгодог болохоор "Америкийн урлагийг үзэх боломжгүй газар нутагт үлдэх зам мөр" хэмээн нэрлэгддэг юм .

<https://art.state.gov>

Welcome

My wife Eloisa and I love the art we've accumulated over the years through a life of travel and of serving our country abroad, but getting wonderful works through Art in Embassies is a unique privilege. It allows us to showcase American art and, in so doing, highlight aspects of our country that are particularly meaningful to us. Hence our focus, in our Art in Embassies exhibition, on creativity and diversity—the qualities that make us so proud of the United States.

We feel incredibly fortunate to have the works of world-renowned artist Nam June Paik (July 20, 1932-January 29, 2006), who is often hailed as the “father of video art.” His *Electronic Super-Highway* is among the most beloved works in the Smithsonian American Arts Museum, and crowds similarly flock to his creations in other museums throughout the world. Nam June Paik broke new ground through his video art; we love not just his path-breaking use of the technology of his era, of course, but how it shed creative new light – sometimes with a sense of humor, sometimes conveying darker messages – on the reality of his day, and ours.

We feel even more privileged to bring Nam June Paik to Mongolia, however, because he believed that he had Mongolian roots. That is what we first learned from our friend Ken Hakuta, who is both the nephew of the artist and executor of his will. The ger that features in *Mongolian Tent*, one of Nam June Paik's well-known works, is perhaps the most obvious piece of evidence of that. We are grateful to Ken for sharing some works in his collection with us through Art in Embassies.

American communities are full of dynamic centers of cultural creativity, and the other part of our exhibition highlights what is surely among the most famous such centers, New York City, which Eloisa and I call home. The New York City artists in our Art in Embassies exhibition are diverse in background, interests, and style, but the city's energy nurtures the creative spirit of them all. We love the individual pieces the artists have lent us, but love, even more, the vibe their works give off as a collection. We are also grateful to John Sillings, founder of Arts in Res, which identifies making art collecting more accessible, more personal, and more fun as its mission. Arts in Res says it “wants to get art out of storage (where most of it lives) and into the world...,” and we are pleased that these works can be displayed far from New York, hopefully adding new dimensions to Mongolia's own wonderfully creative cultural scene. Introducing American art to foreign audiences to create cultural dialogue and bring our countries even closer together is, after all, what Art in Embassies is all about.

Ambassador Michael S. Klecheski

Ulaanbaatar
March 2020

Тавтай морилно уу

Эхнэр Элойса бид хоёр гадаад дотоодоор аялж, хилийн чанадад эх орноо төлөөлөн ажилласан он жилүүдэд цуглуулсан урлагийн бүтээлүүддээ хайртай ч “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрөөр дамжуулан гайхалтай уран бүтээлүүдийг танилцуулна гэдэг хосгүй аз завшаан юм. Энэ нь Америкийн урлагийг олны хүртээл болгохын сацуу ялангуяа бидний хувьд эрхэм зүйлсийг онцлон харуулах боломж олгодог билээ. Тийм ч учраас “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрөөс сонгон толилуулж буй энэхүү үзэсгэлэндээ бидний хувьд Америкийн Нэгдсэн Улсаараа бахархах сэтгэлийг төрүүлж байдаг бүтээлч сэтгэлгээ, олон янз байдлыг онцолж байна.

Бид “видео урлагийн эцэг” гэгддэг, дэлхийд цуутай уран бүтээлч Нам Жүн Пайкын (1932 оны 7-р сарын 20 - 2006 оны 1-р сарын 29) уран бүтээлийг энд авчирсандаа туйлын баяртай байна. “Цахилгаан супер хурдны зам” хэмээх бүтээл нь Смитсоны Америкийн урлагийн музейн алдартай бүтээлүүдийн нэг бөгөөд дэлхий даяар олон музейд түүний уран бүтээлийг үзэгчид тойрон шавж байдаг. Нам Жүн Пайк нь видео урлагаараа дамжуулан шинэ эрин үеийг эхлүүлсэн гэж үздэг. Амьдарч байсан цаг үеийнхээ техник технологийг тун шинэлэг байдлаар ашигласан нь төдийгүй заримдаа хошигнол, заримдаа бараандуу мэссэж агуулсан уран бүтээлээрээ бид бүхний бодит амьдралд шинэ гэрэл гэгээг бүтээлч байдлаар тусгаж байгаа нь бидний сонирхлыг гойд татдаг.

Тэрээр өөрийгөө Монгол угсаатай гэж итгэдэг байсан учраас Нам Жүн Пайкын уран бүтээлийг энд авчрахдаа бид туйлын баяртай байна. Ахынх нь хүү бөгөөд гэрээслэлийг нь гүйцэтгэгч, бидний анд Кен Хакутагаас энэ тухай анх сонссон юм. Нам Жүн Пайкын алдартай бүтээлүүдийн нэг болох “Монгол гэр” магадгүй энэ бодлынх нь илэрхий нотолгоо болов уу. “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрөөр дамжуулан өөрийн цуглуулгаас авга ахынхаа зарим уран бүтээлийг толилуулж байгаа Кенд талархал илэрхийлье.

Америк орон даяар урлаг, соёлын бүтээлч сэтгэлгээний эрчимтэй хөгжлийн төвүүд олон байдаг бөгөөд манай үзэсгэлэнгийн нөгөө нэг хэсэг нь тэдгээр алдартай төвүүдийн нэг, Элойса бид хоёрын гэр орон Нью-Йорк хотыг онцлох болно. “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрөөс толилуулж буй энэхүү үзэсгэлэнд бүтээл нь тавигдсан Нью-Йоркийн уран бүтээлчид гарал үүсэл, сонирхол, стиль загвараараа өөр хоорондоо ялгаатай ч их хотын эрч хүч тэдний бүтээлч сэтгэлгээг тэтгэж байдаг нийтлэг онцлогтой юм. Уран бүтээлчдийн бидэнд зээлдүүлж буй бүтээл тус бүр гойд таашаал бэлэглээд зогсохгүй коллекц хэлбэрээрээ маш онцгой эрч хүчийг цацруулж байгаа нь гайхалтай. Урлагийн бүтээл цуглуулах ажлыг илүү хүртээмжтэй, хувь хүний онцлогт тохирсон, сонирхолтой болгох гэсэн эрхэм зорилго бүхий “Art in Res” галерейг үүсгэн байгуулагч Жон Силлингст бид бас талархал илэрхийлж байна. “Art in Res” нь “ихэвчлэн агуулахад хадгалагдаж байгаа уран бүтээлүүдийг дэлхий ертөнцтэй хуваалцахыг хүсдэг...” учраас холын Нью-Йоркоос авчирсан эдгээр бүтээлүүд гайхалтай бүтээлч сэтгэлгээ бүхий Монголын соёл урлагийн ертөнцөд шинэ хэмжээсүүдийг нэмэх болов уу хэмээн бид найдаж байна. Америкийн урлагийг гадаадын үзэгч олонд толилуулснаар соёлын харилцан яриаг өрнүүлж, хоёр улсын харилцааг улам бэхжүүлдэг бөгөөд энэ нь эцсийн дүндээ “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрийн зорилго юм.

Элчин сайд Майкл С. Клечески

Улаанбаатар хот
2020 оны 3 дугаар сар

Bruce Minson (born 1952)

“After miraculously recovering from a serious illness two years after retiring, I realized I had been given the rare second chance to fulfill what I had long hoped for... creating art in my own studio on my own terms.”

Bruce Minson was born and raised in New York City, where he taught English and theatre arts to New York high school students for thirty years, in addition to being a writer and director in the Off-Off-Broadway world. After he retired, he enrolled in the

Art Students League of New York and had the good fortune to meet a supportive, influential, and inspiring mentor, as well as a group of exciting quality artists. Minson, after receiving one of the League's major awards, struck out on his own and continued his journey to becoming a studio artist. His work has shown in more than a dozen exhibitions, and the artist is passionately searching for his artistic voice to share with others.

Брюс Минсон (1952)

“Миний бие тэтгэвэрт гараад хоёр жил маш хүндээр өвдсөн ч гайхалтай аз тохиолоор эдгэрснийхээ дараа он удаан жил мөрөөдөж байсан зүйлээ биелүүлэх ховорхон боломж надад дахин олдсоныг ухаарсан юм... Тэр нь өөрийн гэсэн урландаа өөрийн дураар уран бүтээл туурвих явдал байлаа”.

Брюс Минсон Нью-Йорк хотод төрж өссөн бөгөөд Бродвейн жижиг (100 хүртэл суудалтай) театруудад зохиолч, найруулагчаар ажиллахын зэрэгцээ 30 жилийн турш Нью-Йоркийн ахлах сургуулийн сурагчдад утга зохиол, театр

урлагийн хичээл заажээ. Тэтгэвэрт гарсныхаа дараа тэрээр Нью-Йоркийн Урлагийн оюутны холбоонд элссэнээр өөрийг нь дэмжиж урам зориг өгдөг, нөлөө бүхий ментортой болсон төдийгүй чадварлаг уран бүтээлчидтэй танилцах завшаан тохиожээ. Тус холбооноос томоохон шагнал хүртсэнийхээ дараа Минсон тусдаа гарч, урландаа бүтээл туурвилаа үргэлжлүүлсэн юм. Түүний уран бүтээлүүд арав гаруй үзэсгэлэнд тавигдаж, тэрээр уран бүтээлчийн өвөрмөц дуу хоолойгоо илэрхийлж, бусадтай хуваалцах эрэлд шамдсаар байна.

BoneBlack. TitanBuff. TitaniumWhite, 2019

Mixed Media, 16 × 16 × 2 in.

Courtesy of the artist and Art in Res

Хөө хар/зааны ясан шаргал/дун цагаан, 2019

Холимог техник, 40,6 × 40,6 × 5,1 см

Уран бүтээлчийн болон “Art in Res” галерейн зөвшөөрөлтэй



Samantha Morris (born 1995)

“In my artwork, I focus on the idea of an individual traveling through a space; on exploring place through architecture and landscape, abstracted through line, shadow pattern, contrast, and negative space. I am interested in dynamics, what can and cannot be seen.”

Samantha Morris graduated from the University of the Arts in Philadelphia, Pennsylvania, with a Bachelor of Fine Arts degree with an emphasis in painting and drawing. She began her graduate

studies in the Master of Fine Arts program at Pratt Institute in New York this year. Morris also studied at the Paris College of Art in France. Her recent solo exhibitions include *Kanna Rými* at Listhús Gallery in Ólafsfjörður, Iceland, and *The Space Between*, at the University of the Arts. Her selected group exhibitions include *Black and White* at Site:Brooklyn Gallery, *Paperworks* at b.j spoke gallery, and *Space Invaders*, Fountain Street Gallery, all in New York, among others.

Саманта Моррис (1995)

“Уран бүтээл туурвихдаа би аливаа орон зайд аялж буй хэн нэгэн гэсэн санаан дээр төвлөрдөг; тэр дүр нь зураас, сүүдрэн хээ, контраст болон сөрөг орон зайгаар хийсвэрлэгдсэн уран барилга, байгалиар дамжуулан орон зайг судалж шинжилдэг. Би өөрөө эрчимт хөдөлгөөн, нүдэнд ил харагдах ба харагдах боломжгүй зүйлүүдэд хөтлөгддөг.”

Саманта Моррис нь Пенсильвани мужийн Филадельфийн Урлагийн их сургуулийг уран зураг, зураасан зургаар дагнан бакалаврын зэрэгтэй төгсчээ. Тэрээр энэ жилээс Нью-Йоркийн Пратт сургуульд дүрслэх урлагийн чиглэлээр магистрын зэрэг горилон суралцаж эхэлсэн байна.

Моррис Францад Парисын урлагийн коллежид мөн суралцаж байв. Тэрээр хамгийн сүүлд Исланд Улсын Оулафсфьордюрин Листус галерейд “Канна Рими” бие даасан үзэсгэлэн, Урлагийн их сургуульдаа “Завсрын орон зай” үзэсгэлэнгээ тус тус гаргажээ. Зөвхөн Нью-Йорк хотод тавигдсан хамтарсан үзэсгэлэнгүүдээс нь дурдвал Сайт: Бруклин галерей дахь “Хар ба цагаан”, Би Жэй Спөук галерей дахь “Цаасан урлал”, Фаунтэн Стрийт галерей дахь “Орон зайг эзэгнэгчид” зэрэг багтана.

Skuggi, 2019

Oil on Panel, 48 × 36 in.

Courtesy of the artist and Art in Res

Сүүдэр (исланд хэлээр), 2019

Тосон будаг, хавтан, 121,9 × 91,4 см

Уран бүтээлчийн болон “Art in Res” галерейн зөвшөөрөлтэй



Nam June Paik (1932–2006)

“Skin has become inadequate in interfacing with reality. Technology has become the body’s new membrane of existence.”

Nam June Paik brought the television to fine art, treating it as a tactile and multisensory medium and object. Trained as a classical pianist, he came into contact with protagonists of the counterculture and avant-garde movements of the 1960s through his early interests in composition and performance. This engagement profoundly shaped his outlook at a time when electronic images were becoming increasingly present in everyday life. His groundbreaking work is considered seminal to the development of video art.

Born in Seoul, Paik fled with his family in 1950 to escape the Korean War. After graduating from the University of Tokyo, Japan, in 1956, he moved to West Germany to continue his studies. There he met the composers Karlheinz Stockhausen and John Cage, as well as the conceptual artists George Maciunas and Joseph Beuys, all of whom shaped his thoughts on performance. He joined the Fluxus group in 1962 and began experimenting with television sets and their screens. Two years later, Paik, living in New York City, met the cellist Charlotte Moorman, a central figure of the city’s avant-garde, and the two began a collaboration that would last until her death in 1991. Paik created many of his most well-known works for Moorman, including *TV Bra for Living Sculpture* (1969) and *TV-Cello* (1971).

Prior to moving to the United States, Paik had met the engineer Shuya Abe, who would become a longtime collaborator as well as his assistant. Abe helped Paik make his first robot, *Robot K-456*, in 1964. Composed of metal fragments, fabric, a data recorder, and a loudspeaker that plays recordings of speeches by John F. Kennedy, *Robot K-456* captures Paik’s interest in merging popular media and technology with human traits. Paik showed this remote-controlled robot in several exhibitions and performances in New York throughout the 1960s. In 1982, during his first major museum exhibition at the Whitney Museum of American Art, he took *Robot K-456* out into the street to orchestrate an “accident”: the robot walked down Madison Avenue and was hit by a car as it attempted to cross 75th Street. For Paik, this spectacle represented a “catastrophe of technology in the twentieth century.”

Alongside his robotic works, Paik maintained a dynamic drawing practice, in works on paper and in multimedia sculptures and installations. His modified television sets combined the moving image with the free, expressive gesture of abstraction. Using brightly colored markers, paints, and other materials, Paik would add expressive layers to the screens.

Нам Жүн Пайк (1932–2006)



“Зөвхөн арьсаараа бодит байдалтай нүүр тулах нь хангалтгүй болсон. Техник технологи бидний бие махбодийн оршихуйн шинэ бүрхэвч болжээ.”

Нам Жүн Пайк бол зурагтын төхөөрөмжийг бодит биет төдийгүй олон мэдрэхүүд зэрэг нөлөөлөх хэрэгсэл хэмээн үзэж, дүрслэх урлагт анхлан нэвтрүүлсэн уран бүтээлч юм. Сонгодог төгөлдөр хуурчаар мэргэшсэн тэрээр 1960-аад оны соёлын эсрэг урсгал болон авангард хөдөлгөөний гол төлөөллүүдтэй тоглолт, хөгжмийн зохиолуудаараа холбогдож нөхөрлөсөн нь электрон дүрслэл өдөр тутмын амьдралд улам бүр хүч түрэн орж ирж байсан тэр цаг үеийг харах өнцөгт нь гүнзгий нөлөөлжээ. Түүнийг алдаршуулсан гоц бүтээл нь видео урлагийн хөгжлийн суурийг тавьсанд тооцогддог.

Сүүл хотод төрсөн Пайк Солонгосын дайнаас зугтан 1950 онд гэр бүлийн хамт дүрвэжээ. 1956 онд Японы Токиогийн их сургуулийг төгсөөд эрдэм номоо үргэлжлүүлэхээр Баруун Герман луу нүүсэн байна. Тэнд хөгжмийн зохиолч Карлхайнз Стокхаузен, Жон Кейж болон концептуал уран бүтээлч Жорж Мачюнас, Жозеф Беус нартай танилцсан нь уран бүтээлийн тухай үзэл бодлыг нь төлөвшүүлжээ. Улмаар 1962 онд Флуксус бүлэгт нэгдэж, зурагтын төхөөрөмж, дэлгэц ашиглан туршилтын ажлаа эхлүүлжээ. Хоёр жилийн дараа Пайк Нью-Йорк хотод амьдарч байхдаа хотын авангард хөдөлгөөний гол фигур болох морин хийлч Шарлотт Мүүрмэнтэй учирснаар 1991 он буюу Мүүрмэнийг нас барах хүртэл нь үргэлжилсэн уран бүтээлийн хамтын ажиллагаа эхэлсэн түүхтэй. Пайк алдартай олон бүтээлээ Мүүрмэнд зориулсны дотор “Амьд барималд зориулан зурагтаар хийсэн хөхний даруулга” (1969), “Телевиз-морин хийл” (1971) зэрэг бүтээлүүд багтана.

Пайк АНУ руу нүүхээсээ өмнө инженер Абэ Шуяатай танилцсан бөгөөд тэрээр он удаан жил Пайкийн хамтрагч бөгөөд туслахаар ажиллажээ. 1964 онд Пайк “Робот К-456” хэмээх анхны роботоо зохиоход нь Абэ тусалжээ. Метал хэсгүүд, даавуу, өгөгдөл хураагч болон Жон Ф. Кеннедийн ярианы бичлэгийг тоглуулах чанга яригчаас бүрдсэн “Робот К-456” нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, технологийг хүний шинж чанартай хослуулах гэсэн Пайкийн хүслийн биелэл нь болжээ. Алсын удирдлагатай энэхүү роботоо Пайк 1960-аад онд Нью-Йорк хотод хэд хэдэн үзэсгэлэн, тоглолтуудаар хүмүүст үзүүлсэн байна. 1982 онд Америк урлагийн Уитни музейд тавигдсан анхны томоохон үзэсгэлэнгийнхээ үеэр тэрээр “Робот К-456”-ийг гудамжинд гарган “ослын” туршилт хийсэн байна. Робот Мэдисоны өргөн чөлөөгөөр алхан 75-р гудамжинд гарцаар гарах гэж яваад машинд дайруулжээ. Пайкын хувьд энэ үзүүлбэр нь “20-р зууны технологийн сүйрлийг” илтгэн харуулжээ.

Роботоос гадна Пайк цаасан дээр зурах, мультимедиа баримал, инсталляц хийх зэргээр урын сангаа баяжуулж байв. Зурагтыг урлагийн бүтээл болгохдоо хөдөлгөөнт дүрсийг чөлөөт, утга төгөлдөр хийсвэрлэлтэй хослуулсан байдаг. Тод өнгийн маркер, будаг, бусад материалуудыг ашиглан Пайк дэлгэцэн дээр илэрхийлэмж бүхий үе давхаргуудыг нэмдэг байв.



Diatonic, 1988
 Acrylic paint on canvas with additions of television antenna, 30 x 60 in.
 Courtesy of the Nam June Paik Estate

Долоон эгшиг 1988
 Зотон, акриль, зурагтын антен, 76,2 x 152,4 см
 Нам Жун Пайкийн гэр-музейн зөвшөөрөлтэй

Singer TV, undated

Vintage Singer TV with additions of permanent oil marker and acrylic paint, includes retractable antenna

18 × 18 × 18 in.

Courtesy of the Nam June Paik Estate

Зингер зурагт

Сунадаг антен бүхий хуучны Зингер зурагтыг тосон ба акриль будгаар будсан

45,7 × 45,7 × 45,7 см

Нам Жун Пайкийн гэр-музейн зөвшөөрөлтэй





Motorola Television, 2005

*Vintage television cabinet with additions of permanent oil marker and acrylic paint, 16 ¾ × 11 7/8 × 13 in.
Courtesy of the Nam June Paik Estate*

Моторола зурагт 2005

*Хуучны зурагтын эх биеийг тосон ба акриль будгаар будсан, 42,5 × 30,2 × 33 см
Нам Жун Пайкийн гэр-музейн зөвшөөрөлтэй*

Max Sarmiento (born 1995)

“As a son of two Ecuadorian immigrants, and inspired by the struggles and pain that we as a family and other immigrants and people of color have gone through, I picked up a brush and set out on a mission. Drawing from the bold colors and flatness of traditional South American art, my paintings seek to share stories from my upbringing, culture, and roots.”

Max Sarmiento is an artist who lives and works in Queens, New York. Sarmiento received his Bachelor of Arts degree in architectural studies from Ithaca College, New York, and through his education, he found a passion for art making and painting.

Inspired by working with lines, colors, and wood, the artist decided to use his craft to tell the stories of immigration and prosperity and life in Queens. As an artist, he has promoted art and communities that include people of color and immigrants. He believes the best way to do that is to connect with the youth in the community and show them their own abilities to prosper and succeed both artistically and in life. Sarmiento currently works with the Queens Museum and El Museo Del Barrio as a teaching artist, working with local youth in creating art and discovering art that resonates with and represents them.

Макс Сармиенто (1995)

“Эквадорын цагаач хосын хүү би вээр манай гэр бүл, бусад цагаач, өнгөт арьстан хүмүүсийн туулж буй амьдрал, зовлон гунигаар хөглөгдсөөр бийр будаг нийлүүлэх аянд шуударсан билээ. Өмнөд Америкийн уран зурагт уламжлал болсон тод өнгө, хавтгай проекцийн арга техник ашиглан өөрийн соёл, хүмүүжил, гарал үүсэлтэй холбоотой түүхүүдийг өгүүлэхийг зорьдог.”

Макс Сармиенто нь Нью-Йорк хотын Куинз дүүрэгт амьдарч, туурвидаг уран бүтээлч юм. Сармиенто Нью-Йоркийн Итака коллежийг уран барилга судлалын бакалавр зэрэгтэй төгсөөд улмаар уран зураг, бүтээл туурвилд зүрх сэтгэлээ өгсөн нэгэн. Тэрээр бүтээлдээ шугаман зураас, олон өнгө, мод ашигладаг бөгөөд

гол төлөв цагаачлал, хөрөнгө чинээлэг байдал, мөн Куинз дүүргийн аж амьдралын тухай хүүрнэсэн бүтээлүүд туурвидаг. Уран бүтээлчийнхээ хувьд Сармиенто өнгөт арьстан, цагаач иргэдэд хүртээмжтэй урлаг, нийгмийн бүлгүүдийг хөхиүлэн дэмждэг. Ингэхдээ тэрээр дүүрэг, хорооныхоо хүүхэд залуучуудтай холбоо тогтоож, урлагт ч, амьдралд ч хөгжин цэцэглэж, амжилт олж болохуйц авьяас чадварыг нь нээн харуулдаг. Эдүгээ Сармиенто Куинз музей болон Эл Музео Дел Барриотай хамтран ажиллаж, орон нутгийн хүүхэд залуучуудад уран зургаар хэрхэн өөрийгөө илэрхийлж, бүтээж туурвихыг зааж байна.

Ninos la comida esta lista!, 2018

Acrylic on collaged wood, paper and fabric, 17 × 27 in.
Courtesy of the artist and Art in Res

Хүүхдүүд ээ, хоолондоо!, 2018

Акриль, мод, цаас, даавуу, 43,2 × 68,6 см
Уран бүтээлчийн болон “Art in Res” галерейн зөвшөөрөлтэй



Suzanne Unrein (born 1964)

"I frequently have dreams where I'm communing with wild animals... These encounters, real and imagined, feel the same as when I'm painting."

Suzanne Unrein grew up among swamps, alligators, mossy oaks, and hundreds of varieties of birds in the coastal towns of Florida. Her travels and encounters with animals in Mexico, South Africa, Borneo, and Bali have contributed to her vibrant worlds where the animality of humans plays within a world of beasts. A California native and a current New Yorker, her work has been exhibited in galleries and museums throughout the United States, with solo shows in New York City, Los

Angeles, Dallas, Chicago, and the Hamptons. Unrein currently works in her studio in the East Village. She has had residencies at the Studio Program at P.S. 122 in the East Village, New York; the Jentel Foundation in Banner, Wyoming; and the Can Serrat residency in Le Bruc, Barcelona, Spain.

Сьюзанн Анрэйн (1964)

"Зэрлэг амьтадтай ярилцаж байна гэж би байн байн зүүдэлдэг... Эдгээр бодит болон төсөөллийн харилцааны мэдрэмж зургаа зурж байхад бас төрдөг юм."

Сьюзанн Анрэйн Флорида мужид далайн эргийн жижигхэн сууринд, намаг балчиг, гүмбараа матар, хөвдөөр хучигдсан царс модод, зүсэн зүйлийн шувуудын дунд өсч торнижээ. Мексик, Өмнөд Африк, Борнео, Бали зэрэг газруудаар аялах явцад нь тааралдаж байсан төрөл бүрийн ан амьтад түүний уран бүтээлийн амьд, эрчимлэг ертөнц бүрэлдэн бий болоход нөлөөлж, түүн дотор нь хүн төрөлхтний амьтанлаг араншин араатан амьтны ертөнцтэй сүлэлдэн оршдог ажгуу. Калифорнийн уугуул, Нью-Йоркийн суугуул түүний уран бүтээл АНУ даяар галерей,

музейнүүдээр олны хүртээл болсоор ирсэн. Тэрээр бие даасан үзэсгэлэнгээ Нью-Йорк, Лос Анжелес, Даллас, Чикаго, Хамптонт зэрэг хотуудад гаргажээ. Өдгөө Анрэйн Ийст Виллеж дэх урландаа уран бүтээлээ туурвиж байна. Тэрээр Нью-Йоркийн Ийст Виллежийн P.S.122 урлан, Уайоминг мужийн Баннер хотын Жентел сан, мөн Испаний Барселона хотын Ле Брук дүүрэгт Кан Серрат урланд резидент уран бүтээлчээр ажиллаж байв.

Aquarium, 2012

*Oil on canvas, 52 ¾ × 67 ¼ in.
Courtesy of the artist and Art in Res*

Аквариум, 2012

*Зотон тос, 134 × 170,8 см
Уран бүтээлчийн болон "Art in Res" галерейн зөвшөөрөлтэй*



Rachael Wren (born 1976)

"I am drawn to moments in nature when form and space seem to mingle when edges disappear and atmosphere becomes all-encompassing—fog playing between tree branches, light shining through clouds, the water's horizon as it meets the sky."

Rachael Wren received a Bachelor of Arts degree from the University of Pennsylvania, Philadelphia, and a Masters in Fine Art from the University of Washington, Seattle. She has exhibited her work in galleries and museums nationally

and internationally, including the National Academy Museum (New York), the Weatherspoon Art Museum (Greensboro, North Carolina), the Teckningsmuseet (Laholm, Sweden), and Wave Hill (New York). Wren is the recipient of the Julius Hallgarten Prize from the National Academy Museum and an Aljira Fellowship. She lives and works in Brooklyn, New York.

Рэйчэл Врэн (1976)

"Манан будан модны мөчир дамжин наадаж, үүлс нэвтлэн гэгээ татах, усны мандал тэнгэрийн хаяатай уусах зэргээр байгальд хэлбэр дүрс орон зайтай сүлэлдэж, зааг хязгаар арилан замхраад агаар мандал бүхнийг нөмрөн авах мөчүүд миний сэтгэл зүрхийг эзэмддэг ."

Рэйчэл Врэн Филадельфи дэх Пенсильванийн их сургуулиас соёл урлагийн бакалаврын зэргээ хүртэж, Сиэтл дэх Вашингтоны их сургуулийг дүрслэх урлагийн магистр зэрэгтэй дүүргэжээ. Тэрээр үндэсний төдийгүй олон улсын музей,

галерейнууд, түүний дотор Үндэсний академийн музей (Нью-Йорк), Ведерспүүн урлагийн музей (Хойд Каролина муж, Грийнсборо), Текнингсмусеет (Швед, Лахольм) болон Вейв Хилл соёлын төв (Нью-Йорк) зэрэгт уран бүтээлээ дэлгэн үзүүлж байв. Рэйчэл мөн Үндэсний академийн музейн Жулиус Холлгартены шагнал, Алжира контемпорари урлагийн төвийн тэтгэлэг хүртсэн юм. Тэрээр Нью-Йоркийн Бруклинд амьдарч, туурвиж байна.

Portent, 2008


Oil on linen, 48 × 48 in.

Courtesy of the artist and Art in Res

Ёр зөн, 2008

Зотон тос, 121,9 × 121,9 см

Уран бүтээлчийн болон "Art in Res" галерейн зөвшөөрөлтэй



Acknowledgments/ Талархал

Washington, D.C./ Вашингтон Ди Си

Welmoed Laanstra, Curator/ *Велмүүд Лаанстра, музейн эрхлэгч*
Danielle Giampietro, Registrar/ *Даниелл Жиапьетро, бүртгэл хөтлөгч*
Tabitha Brackens, Managing Editor/ *Табиата Бракенс, ахлах редактор*
Tori See, Editor/ *Тори Сий, редактор*
Amanda Brooks, Imaging Manager/ *Аманда Брүүкс, имиж менежер*

U.S. Embassy Ulaanbaatar/ Улаанбаатар дахь АНУ-ын Элчин сайдын яам

Phillip Steinhauer, Facility Manager/ *Филлип Стайнхаузер, Барилга байгууламжийн хэлтсийн менежер*
Javkhlan Ganbold, General Service Office Senior Specialist/ *Ганболдын Жавхлан, Нийтлэг үйлчилгээний хэлтсийн ахлах ажилтан*
Myagmarsuren Jamyansuren, Painter/Carpenter/ *Жамьянсүрэнгийн Мягмарсүрэн, мужаан*
Enkhbat Zagdsuren, FMS Assistant/ *Загдсүрэнгийн Энхбат, өрлөгчин*
Ganbat Dondov, FMS Assistant/ *Дондовын Ганбат, туслах ажилтан*
Sugarsuren Batbayar, Travel Assistant/ *Батбаярын Сугарсүрэн, Тээврийн хэлтсийн ажилтан*
Tuul Chogsomjav, Translator/ *Чогсомжавын Туул, орчуулагч*
Public Affairs Office/ *Олон нийттэй харилцах алба*

-
Otgonbaatar Tsedendemberel, Translator/ *Цэдэндэмбэрэлийн Отгонбаатар, орчуулагч*

-
Crown Relocation crew/ *Crown Relocation компанийн хамт олон*

-
Special thanks to Ken Hakuta for sharing the works of his uncle, Nam June Paik, from his collection,
and John Sillings, founder of Art in Res, for lending the works of New York City artists.

*Авга ах Нам Жун Пайкынхаа цуглуулгаас толилуулахыг зөвшөөрсөн Хакута Кен болон Нью-Йорк хотын уран бүтээлчдийн
бүтээлийг зээлдүүлж буй "Art in Res" галерейн үүсгэн байгуулагч Жон Силлингс нарт тусгайлан талархал илэрхийлж байна.*

Vienna/ Вена

Nathalie Mayer, Graphic Designer/ *Натали Мэйер, График дизайнер*

Manila/ Манила

Global Publishing Solutions, Printing/ *компани*



Published by Art in Embassies | U.S. Department of State, Washington, D.C. | March 2020 | <https://art.state.gov/>